



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/033

Хэрлэн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Дэлхийн зөн Монгол Олон улсын байгууллагын Бор-Өндөр 2 хөтөлбөрийн хамтын ажиллагааны хүрээнд үр дүнгийн баяр арга хэмжээг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн

дарга:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Нарийн бичгийн

дарга:

Дэлхийн зөн Монгол Олон улсын байгууллагын Бор-Өндөр 2 хөтөлбөрийн менежер (зөвшилцсөнөөр)

Гишүүд:

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн нийгмийн хамгааллын бодлого хариуцсан мэргэжилтэн

Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга

Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газрын дарга

Ардын дуу бүжгийн Хан Хэнтий чуулгын дарга

Дэлхийн зөн Монгол Олон улсын байгууллагын Бор-

Өндөр 2 хөтөлбөрийн ажилтан (зөвшилцсөнөөр)

Аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн

(зөвшилцсөнөөр)

2. Ажлын хэсгийг удирдлага арга зүйгээр ханган ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Зоригтбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

D:\My Documents\ Захирамж-2024

231010851